



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn


2026.04.21 № УИХ-01/4246
танай _____-ны № _____-т

Улсын Их Хурлын гишүүдийн
асуулт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын асуулгын цагаар Ерөнхий сайдад тавих Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т "Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна." гэж заасны дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА



С.БЯМБАЦОГТ

2026000165

Монгол Улсын Их Хурлын 2026 оны
04 дүгээр сарын 24-ний өдрийн
УИХ-01/4246 дугаар албан бичгийн
хавсралт

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 24-ний өдрийн Баасан гарагийн нэгдсэн хуралдааны
Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайдаас асуухаар ирүүлсэн
Улсын Их Хурлын гишүүдийн асуулт**

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	Сэдэв: Авлигажуулсан Монгол <ul style="list-style-type: none">• Та Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд авлигыг бууруулж чадах уу?
2	Ц.Баатархүү	Сэдэв: Авлигажсан Монгол 1.Авлигатай тэмцэх талаар олон бодлого яригддаг ч бодит үр дүн сул байна. Та ойрын 1-2 жилд авлигыг бууруулсан гэдгийг нотлох 3 тодорхой үзүүлэлт, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, мөн хариуцлага хүлээх албан тушаалтнуудыг нэрлэж өгч чадах уу?
3	Д.Батбаяр	Сэдэв: Авлигажсан Монгол 1.Олон улсын авлигын индексээр Монголын авлигын үзүүлэлт ийнхүү “дээд амжилт” тогтоож байгаад гол үүрэг гүйцэтгэсэн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгнө үү. 2.Засаг захиргааны анхан болон дунд шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчид холбогдсон авлигын хэргүүдийн талаар мэдээлэл өгнө үү.
4	Ш.Бямбасүрэн	Сэдэв: Авлигажсан Монгол 1.Авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон, шүүхээр ял шийтгүүлсэн төрийн өндөр дээд албан тушаалд ажиллаж байсан хүмүүс нам, улс төр, төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой байх нь төрд, хууль тогтоох байгууллагад итгэх иргэдийн итгэл сулрах үндэс болж байгаа гэдэгтэй та санал нийлэх үү? Энэ асуудал дээр таны байр суурь? 2.Улс төрд нөлөө бүхий этгээдийн зүгээс арилжааны банкаар хийгдэж байгаа сэжигтэй гүйлгээг шалгадаг, мэдээллэдэг бүтэц Монголбанк дээр байгаа. Үүнийг Санхүүгийн мэдээллийн алба гэдэг. Арилжааны банкуудаас хэчнээн тохиолдол СМА-д мэдээлэгдээд хэчнэнийг нь шалгаж, нягталсан бэ гэдэг тоо мэдээ байна уу? Үндэслэлгүй хөрөнгөжсөн байж болзошгүй улс төрд нөлөө бүхий этгээдийг илрүүлэх, шалгах энэ мэт үйл ажиллагаа Монгол Улсад ямар хэмжээнд хэрэгжиж байна вэ?
5	А.Ганбаатар	Сэдэв: Авлигажуулсан Монгол 1.Транспэрэнси Интернэшнл байгууллагын 2025 оны Авлигын төсөөллийн индекс-д Монгол Улс 31 оноотойгоор 182 орноос 124 дүгээр байрт орж, өмнөх оноос 10 байр ухарчээ. 10 байр ухрах болсон гол шалтгаанд авлигын талаар ил болсон мэдээлэл болон хариуцлага тооцох явцын хоорондын зөрүү асар их хэвээр байна гэж дүгнэжээ. Иймд олон нийтэд ил болсон авлига, хулгайн хэргүүд

		хэзээ шийдэгдэх вэ, түүнд нэр холбогдсон улс төрчид хэзээ хариуцлага хүлээж, төрд учирсан хохирол хэзээ төлөгдөх вэ?
6	Б.Жаргалан	Төсөл хөтөлбөрийн төсвийг үндэслэлгүй өсгөдөг "авлигын шимтгэл"-ийн талаар Таны бодол?
7	Л.Мөнхбаясгалан	Сэдэв: Авлигажсан Монгол <ul style="list-style-type: none"> • Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон болон ял шийтгэгдсэн этгээдүүдийг төрийн албанд томилон ажиллуулах нь зөв үү?
8	Г.Очирбат	Сэдэв: Авлигажсан Монгол <p>1.Та авлигыг дээд шатанд удирдаж, дунд, доод шатанд хэрэгжүүлдэг тогтолцоо Монгол Улсад бий болсон гэдэгтэй санал нэгдэх үү?</p> <p>2.Танд бүрэн эрхээ хэрэгжүүлэх 2 жил гарангын хугацаа байна. Энэ хугацаанд Монгол Улсын авлигын индексийг яг хэдэн хувиар бууруулж чадах вэ?</p> <p>3.Та авлигатай тэмцдэг Засгийн газар бүрдүүлж чадсан гэж үздэг үү. Танай Засгийн газраас хэн нэгэн сайд авлига, албан тушаалын хэргийн асуудалтай холбогдвол та шууд огцорч чадах уу?</p>
9	Ө.Шижир	Нэг. Эрүүгийн хуулийн Хоринхоёрдугаар бүлгийн хэрэгжилт. <p>Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт авлига, албан тушаалын гэмт хэргийг зүйлчилсэн байдаг бөгөөд тус бүлэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан албан тушаалтнаас гадна хахууль өгсөн этгээд, хуулийн этгээдийг хамруулсан.</p> <p>Дээрх тодорхой хуулийн үйлчлэлд хамаарч буй этгээдүүдэд холбогдуулан гэмт хэрэг шалган шийдвэрлэх байгууллагуудад ирүүлсэн гомдол мэдээллийн тоо болон хэрэгжилт, шийдвэрлэлтийн талаар сүүлийн 10 жилийн судалгаа, үр дүнгийн тайлан мэдээллийг багцлан танилцуулна уу.</p> <p>Хоёр.Нийгэмд дуулиан тарьсан авлига, албан тушаалын гэмт хэргүүдийн шийдвэрлэлт.</p> <p>Сүүлийн 10 жилд Төрийн эрх барих дээд байгууллагын сонгуульд Монгол Ардын Нам хэт олонх, олонхын байр суурийг авч 6 дахь Засгийн газраа байгуулан ажиллаж байна. Энэ хугацаанд нийгмийн бухимдлыг өдөөж туйлд нь хүргэсэн хэдэн тэрбум, их наядын авлига, хулгайн хэргүүд ээлж дараалан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ил болсон.</p> <p>Улсын төсөв, инфляц, дарга нарын тансаглал сүүлийн 10 жилд үлэмж өссөн боловч иргэдийн амьжиргаа, худалдан авах чадвар, цалин, тэтгэвэр, төгрөгийн ханш уялдан өссөнгүй. Харин тухайн цаг үе, улс төрийн үзэгдэл байсан мэт дуулиант хэдэн тэрбум, их наядын гэмт хэрэг, хулгайн асуудал замхран алга болсоор байна.</p> <p>Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь улс төрийн захиалгатай мэдэгдэл хийдэг, бага хэмжээний буюу хэдэн арав, зуун сая төгрөгийн хурган дарга нарын гэмт хэргийг илрүүлдэг хэр нь хэдэн тэрбум, их наядын улс төрчдийн хулгай, гэмт хэргийг илрүүлж чаддаггүй болсон байна.</p> <p>Иймээс доор нэр дурдсан авлига, хулгайн гэмт хэргүүд хэрхэн шийдвэрлэгдэж, хэдэн төгрөгийн хохирлыг улсад буцаан барагдуулсан, хэдэн албан тушаалтан хариуцлага хүлээсэн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.</p>

		<p>Төрийн нууцад авсан нүүрсний хулгайн гэрээнүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нүүрсний 9 оффтэйк гэрээ- 2022 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл; 2. Нийт нүүрсний 38 оффтэйк гэрээ; 3. Нүүрсний нууц гэрээ /39 нууц гэрээ гэх/; <p>Бусад хулгайн хэргүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан; 2. Хөгжлийн банк; 3. Нийгмийн даатгалын сангийн хулгай; 4. Эрдэнэт үйлдвэр; 5. Төмөр зам, нүүрсний оффтэйк; 6. Ногоон автобус; 7. Боловсролын зээлийн сан; 8. Ковидын үеийн худалдан авалтууд. <p>Гурав.Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна уу?</p> <p>Монгол Улсын холбогдох хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт шүгэл үлээгчийг хамгаалах тухай зохицуулалт бий. Гэвч нийтийн албан тушаалтны дарамт, шахалтын улмаас бизнес эрхлэгчид, хувь хүн хахууль өгөх тохиолдол бодитоор оршсоор байна.</p> <p>Бизнесийн тасалдалгүй үйл ажиллагаагаа явуулах нөхцөл боломж, зайлшгүй шаардлагатай тохиолдолд тодорхой дарамт шахалтын дор хахууль өгөх явдал амь бөх байна. Уг асуудлаас үүдэн тодорхой дарамтын улмаас хахууль өгсөн бол Эрүүгийн хуулийн 22.5-д заасан “Хахууль өгөх” гэмт хэргээс хэрхэн салгаж хэрэг хянах, мөрдөн байцаах ажиллагаа хийгдэх вэ? Шүгэл үлээгчийг хамгаалах бодлого бодитоор хэрэгжиж байгаа юу?</p> <p>Дээрх гурван асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газарт бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээ зорилт үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа эсэх талаар мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганд танилцуулж, мөн бичгээр хариу ирүүлж өгөхийг Монгол Улсын Ерөнхий сайдаас хүсэж байгаа тул уламжилж өгөхийг танаас хүсье.</p>
10	С.Эрдэнэболд	<ol style="list-style-type: none"> 1.Төрийн нэр барьж, эрх мэдэлд ойр бүлэглэлүүд төсөв, тендер, томилгоо, лиценз, төрийн өмчит компанийн шийдвэрийг өөрсдийн ашиг сонирхолд үйлчлүүлдэг “авлигажсан бүлэг”-ийн шинжтэй сүлжээ бий болсон гэж иргэд үзэж байна. Таны хувьд ийм бүлэглэл бодитоор оршиж байна гэж үзэж байна уу, үгүй юу? Хэрэв байна гэж үзэж байгаа бол Засгийн газар түүнийг задлахын тулд ямар улс төрийн шийдвэр, ямар бодит арга хэмжээ авах вэ? 2.Авлига ганц нэг албан тушаалтны асуудал биш, харин хамгаалалттай, нөлөөллийн, харилцан ашиг сонирхлын сүлжээ болсон үед улс төрийн хариуцлага хамгийн түрүүнд яригдах ёстой. Тэгвэл Ерөнхий сайд Та өөрийн танхим, эрх баригч нам, төрийн өмчит компаниуд, агентлагуудын хүрээнд ийм нөлөөллийн сүлжээ байхгүй гэдгийг улс төрийн хувьд хариуцлагатайгаар хэлж чадах уу? Эсвэл байгаа бол нэр бүхий салбар, түвшинд нь шалгаж, цэвэрлэх улс төрийн зориг танай Засгийн газарт байна уу? 3.Иргэдийн дунд “авлигажсан бүлэглэлүүд хууль, хяналтын байгууллага, улс төр, бизнесийн ашиг сонирхлыг нэгтгэж, хариуцлагаас мултардаг” гэсэн төрд үл итгэх байдал гүнзгийрч байна. Энэ нөхцөлд Ерөнхий сайдын хувьд авлигатай тэмцэх тухай

		ерөнхий үг биш, харин эрх мэдэл төвлөрсөн, ашиг сонирхлын сүлжээ болсон бүлэглэлүүдийг ил тод болгох, хөрөнгө орлогын зөрчлийг шалгах, томилгооны нөлөөллийг таслах, төрийн худалдан авалтыг нээлттэй болгох чиглэлээр яг ямар хугацаатай, хэмжигдэхүйц алхмууд хийх вэ?
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ		
11	О.Саранчулуун	<p>Асуудлын хүрээ: Хууль тогтоомжийн биелэлт</p> <p>1.Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1.7 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Арга зам: Цочмог, цочмогдуу үеийн нөхцөл байдалд хариу үзүүлэх үйлчилгээг төрөлжүүлэх гэж заасан. Энэ ажил ямар явцтай байгаа вэ?</p> <p>Асуудлын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>1.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.25.Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана - Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2025 оны 12 дугаар сард “Замын зураглал” боловсруулсан. Замын зураглалыг 3 яаманд 2026 оны 1 дүгээр сард хүргүүлсэн. Энэ жил Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам манлайлж “Үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж, Засгийн газрын тогтоол гаргах ёстой. Энэ ажил ямар шатанд явж байгаа вэ?</p> <p>Асуудлын хүрээ: Тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт</p> <p>1.2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордонд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт ба улсын төсөв: Санхүүгийн бодлогыг хүний эрхэд нийцүүлэх нь” үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс анх удаа 2026 оны улсын төсөвт хувь нэмрээ оруулж, дуу хоолойгоо илэрхийлсэн билээ. Үүний нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оношилгооны тоног төхөөрөмж байсан. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?</p> <p>Асуудлын хүрээ: Бусад асуудал</p> <p>1.Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалаар Төсвийн зарим ангиллыг шинэчлэн баталсан билээ. Ангиллын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид үйл ажиллагаа төлөвлөдөг боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа тэдний эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах дээр зардлын ангилал гаргахгүй хэвээр байна. Сангийн яам энэ тал дээр сургалт зохион байгуулж байгаа талаараа ярьж байсан билээ. 2027 оны Улсын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах талаар ямар зардлын ангилал тавьж, хэрхэн хамтран ажиллах гэж байгаа төлөвлөгөө хэлнэ үү?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
12	Д.Энхтүвшин	<p>Асуудлын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улс орны эдийн засаг, нийгэм</p> <p>1.Өнөөдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиар 34 гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Компанийн холбогдсон хэргийг шалгах явцад тодорхой харгалзах</p>

		<p>нөхцөлгүйгээр дансыг нь хаах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг нь хязгаарладаг, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх асуудлууд гардаг. Хуулийн этгээдэд холбогдох мөрдөн шалгах ажиллагааны процесс тодорхойгүй байгаа бөгөөд мөрдөгч, прокурорын санаачилгаар тодорхой хугацаагүй хэрэгждэг. Компанитай холбогдуулан хуулийн байгууллагаас хугацаагүй, харгалзах нөхцөлгүй ирдэг дээрх асуудал чөлөөлөх санаачилгын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хамаарах уу?</p> <p>2.Татварын хуулийн төслийг буцаан татсан. Эргэж оруулж ирэхдээ дансыг хаадаг, дансан дахь мөнгийг нь шалгуургүйгээр татдаг асуудлыг тусгах уу?</p> <p>3.Бизнес эрхлэгч нарт тулгамдаж байгаа гол асуудал ажиллах хүчний хомсдол болсон. Ажиллах хүчний хомсдолтой холбогдуулан ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Энэ зорилгоор оюутан залуучууд, тэтгэвэрт гарсан ахмадуудыг хөдөлмөрийн зах зээлд оролцуулах болон гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрт өөрчлөлт оруулах уу?</p>
13	М.Энхцэцэг	<p>Асуудлын хүрээ: Хууль тогтоомжийн биелэлт</p> <p>1.Сэргээгдэх эрчим хүчний 3х100 хөтөлбөрийг хэзээ хэрэгжүүлж эхлэх гэж байгаа вэ? 2026-2027 онд ядаж 10 мянган айлд 10 кВт-ын нарны панель, 10 кВт.цаг батарей тавих хөтөлбөрийн санхүүжилтийн механизмыг шийдсэн үү?</p> <p>2.Ногоон зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг сайжруулах асуудал юу болж байгаа вэ? Яг хэзээ хэдэн хувь болж буурах вэ?</p> <p>3.Цахилгаан эрчим хүчний өрсөлдөөнт бөөний зах зээл рүү үе шаттай шилжих зах зээлийг либералчлах ажил хэр явцтай байгаа вэ?</p> <p>Асуудлын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ДЦС-4-ыг 500 тн.цаг-аар өргөтгөх төсөл байгаа. Энэ төсөл хэрэгжсэнээр 300 МВт-ын дулааны эх үүсвэр бий болно. Энэ төслийн санхүүжилтийг шийдсэн үү? Хэзээ эхэлж, хэзээ дуусах вэ?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
14	П.Ганзориг	<p>Макро эдийн засаг болон төсвийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> - Дэлхийн геополитикийн нөхцөл байдлын асуудалтай холбоотой Монгол Улсын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллүүд юу байна вэ? Үүнтэй холбоотой ямар бодлого баримталж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ? - 2026 оны төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн төсөөлөл; - Инфляц /шатахууны үнэ/, иргэдийн бодит орлогыг тогтвортой байлгах, хамгаалах тал дээр хэрэгжүүлж буй бодлого, чиглэл. <p>Зээлийн хүүг бууруулах асуудлын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайлбал, банкны салбарын төвлөрөл өндөр байгаа нь хүү буурахгүй байх нэг шалтгаан болж байна. Өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын банк оруулах, эсвэл зах зээлийн бүтэц өөрчлөх бодлого бий юу? Хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? <p>Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг улс төрөөс ангид,</p>

		<p>мэргэжлийн удирдлагаар үр өгөөжтэй өсгөх тал дээр хэзээнээс, хэрхэн ажиллах вэ?</p> <p>- Мөн Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой хийж буй хэлэлцээр одоогоор ямар шатанд явж байгаа вэ?</p> <p>Энэ хэлэлцээрээс бодит үр дүн хэзээнээс гарах вэ?</p>
15	Б.Мөнхсоёл	<p>1.Ипотекийн зээлийн тогтолцооны хэрэгжиж байгаа өнөөгийн байдал, бага дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах төрийн бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн талаарх мэдээлэл.</p> <p>2.Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтцийг орон сууцны талбайн хэмжээ, ашиглалтад орсон хугацаа, ипотекийн зээлийн хүүгээр нь, ипотекийн зээлдэгчийн мэдээллийг орлого, нас, ажиллаж буй салбараар нь мөн хоёроос дээш хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчийн тоог танилцуулна уу.</p> <p>3.Ипотекийн зээлийн тогтолцоонд төрийн албан хаагчид, эмч, багш нар хэр их хамрагдсан талаарх мэдээллийг гаргаж өгнө үү.</p>
ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ		
16	Б.Батбаатар	<p>1.Сүүлийн 10 жил танай нам засаг барихдаа иргэдийн амьдрал бодитоор сайжирсан гэж Та үзэж байна уу - тийм үү, үгүй юу?</p> <p>2.Хэрэв сайжирсан гэвэл бодит орлого, инфляц, ядуурлын аль үзүүлэлтүүдээр үүнийг батлах вэ? Яг тоо, хугацаатай хэлнэ үү.</p> <p>3.Өнөөдөр мах, гурил, шатахууны үнэ иргэдийн орлогоос хурдан өсөж байгааг та амжилт гэж үзэж байна уу, эсвэл бодлогын алдаа гэж үзэж байна уу?</p> <p>4.Дотоодын нийт бүтээгдэхүүн өссөн гэж ярьдаг ч яагаад дундаж ерхийн бодит орлого, худалдан авах чадвар өсөхгүй байна вэ?</p> <p>5.Залуучууд гадагшаа олноор гарч байгаа нь боломж нэмэгдсэний шинж үү, эсвэл дотоод орчин хангалтгүй байгаагийн илрэл үү?</p> <p>6.Томоохон авлигын хэргүүд дээр өндөр албан тушаалтнууд бодитоор ял авсан хэдэн тохиолдол байна вэ? Мөн энэ нь системийн асуудал гэдгийг та хүлээн зөвшөөрөх үү?</p> <p>7.Эрчим хүчний хомсдол жил бүр давтагдаж, хувийн болон гадаад хөрөнгө оруулалттай төслүүд удааширч байхад суурь чадлыг нэмэгдүүлэх болон хувийн хөрөнгө оруулалтыг татах бодлого бодитоор хэрэгжээгүй нь бодлогын алдаа юу, эсвэл хэрэгжилтийн чадавхын асуудал уу?</p> <p>8.Хэрэв дээрх асуудлууд системийн шинжтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байвал яг ямар 3 бодит реформыг, ямар хугацаанд хэрэгжүүлэх вэ?</p> <p>9.Хэрэв Таны хэлсэн бодлого тодорхой хугацаанд бодит үр дүн өгөхгүй бол Та улс төрийн хариуцлага хүлээж, огцрох хүртэл шийдвэр гаргах уу - тийм үү, үгүй юу?</p>
17	М.Нарантуяа-Нара	<p>1.Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэвийн болгох, татвар төлбөрөө барагдуулах, цалин хөлсөө олгох боломжийг нээх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн “Бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих талаар авах арга</p>

		<p>хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолоор Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч хуулийн этгээдийн шүүхийн шийдвэрээр тогтоогдсоноос бусад татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг үл маргах журмаар гаргуулахаар арилжааны банканд дахь битүүмжилсэн дансыг 1 сарын хугацаанд нээсэн.</p> <p>Иймд тус шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дараах асуултыг тавьж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Дээрх шийдвэр гарах хүртэл хугацаанд данс нь битүүмжлэгдсэн байсан аж ахуйн нэгжийн тоон мэдээлэл, тэдгээрийн нийт өрийн хэмжээ, битүүмжлэгдсэн байсан мөнгөн дүн болон тус шийдвэрийн дагуу данс нь нээгдсэн аж ахуйн нэгжийн тоон мэдээлэл;- Аж ахуйн нэгжийн дансыг 1 сарын хугацаанд нээх нь тухайн аж ахуйн нэгжид бодитой дэмжлэг болох эсэх, энэ хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн болох боломжтой эсэх;- Тус шийдвэрийн Улсын төсөв, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөлөл, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл. <p>2.Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар бизнесийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд найман төрлийн 146 бизнесийн үйл ажиллагааг зөвшөөрлөөс чөлөөлөх “Бизнесийн орчныг дэмжих зарим авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталжээ.</p> <p>Энэхүү шийдвэр нь иргэдэд бизнес эрхлэх боломжийг нээж, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэхээр байх боловч иргэдийн аюулгүй байдалд эрсдэл дагуулж болзошгүй байна.</p> <p>Иймд тус шийдвэртэй холбогдуулан дараах асуултыг тавьж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Тухайн шийдвэрээр чөлөөлөгдсөн найман төрлийн 146 бизнесийн үйл ажиллагааг сонгосон шалгуур үзүүлэлтийн талаар;- Тус шийдвэрийн дагуу урьдчилсан хяналтгүйгээр эхлүүлэх бизнесийн улмаас иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол, хор уршиг учруулж болзошгүй эрсдэлээс хамгаалах бодлого, хяналт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.
--	--	--